



SHANDASGOVI

International freight forwarding & logistics company

Бидний тухай

ШАНДАСГОВЬ ХХК нь 2010 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд далайд гарцгүй газар зүйн байрлал, хязгаарлагдмал дэд бүтэц бүхий онцлогтой манай улсын нөхцөл байдалд үйлчлүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн экспорт, импортын бүх төрлийн ачаа, бараа бүтээгдхүүнд тээвэр ложистикийн үйлчилгээний зардлыг хэмнэж, тээвэрлэлтийн хугацааг богиносгох зэрэг тулгамдсан асуудлуудыг мэргэжлийн хамт олны өндөр ур чадвар, оновчтой тээвэр ложистикийн хувилбаруудад үндэслэн үр дүнтэй шийдвэрлэн, Тээврийн салбарын хөгжлийн төлөөх үйлст цаг наргүй зүтгэх Тээвэр зуучийн салбарынхаа нийт байгууллагуудын нэгэн адил хэрэглэгч үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамжыг онцлон анхаарах талаас нь анхаарч харилцан сэтгэл ханамж, өндөр зохион багуулалт, хариуцлагатай байдал, тасралтгүй хөгжил, эерэг хандлага, бүтээлч санаачлага, тогтвортой хамтын ажиллагааг тэргүүн зорилго болгон дэлхийн 5 тивийн 60 гаруй орны 300 гаруй харилцагч түншүүдийн өргөн сүлжээгээрээ дамжуулан дэлхийн өнцөг булан бүрт хүрэн тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Бидний үйлчилгээ

- Төмөр замын тээвэр
- Авто тээвэр
- Агаарын тээвэр
- Далайн тээвэр
- Цуглуулбар ачааны тээвэр
- Төслийн ачааны тээвэр
- Экспортын тээвэр
- Гаалийн бүрдүүлэлт

Төмөр замын тээвэр

Цаг агаарын ямарч нөхцөлд өндөр хурд, ачааны аюулгүй байдал, хямд үнийг үйлчлүүлэгчид олгодог төмөр замын тээврийн үйлчилгээг:

- Балтик болон Брестийн боомтуудаар
- БНХАУ-ын бүх төмөр замын өртөө, боомтоос
- Гуравдагч орнуудаас БНХАУ-аар дамжин Монголруу
- Монголоор дамжин өнгөрөх транзит тээвэр
- Дэлхийн бүс орнуудруу экспорт

АВТО ТЭЭВЭР

- Бид БНХАУ, ОХУ болон Европын холбооны орнуудаас бүх төрлийн хүнсний бүтээгдхүүнээс авхуулаад хүнд даацын тоног төхөөрөмж, уул уурхайн тоног төхөөрөмж дагалдах хэрэгслийг Замын-үүд боомт, Гашуунсухайт, Алтанбулаг боомтоор дамжуулан авто тээврээр хийж байна.

Агаарын тээвэр

Ачаагаа богино хугацаанд яаралтай авах хэрэгцээтэй байгаа бол хамгийн тохиромжтой шийдлийг агаарын тээврийн үйлчилгээгээрээ үзүүлж байна:

- Улаанбаатарлуу шууд нислэг
- Инчоноор дамжин дэлхийн бүх улс орноос хийгдэх агаарын тээвэр
- Дэлхийн бүх улс оронруу экспортын агаарын тээвэр
- Хаалганаас хаалга үйлчилгээ

Дээрхи үйлчилгээг бид танд дэлхийн авиа компаниудын итгэжлэгдсэн, тусгай зөвшөөрөл бүхий агентын сүлжээн дээр тулгуурлан үнэ, хугацааны боломжит сайн нөхцлийг хямд хурдан байхаар гаргаж өгнө. Ачааны хэмжээ ихсэх тусам үнэ хямдрах давуу байдал танд байгааг зөвлөж байна

Далайн тээвэр

Далайд гарцтай орноос ачаагаа өртөг багатай хямд тээвэрлэхийг хүсвэл далайн тээврийг төмөр зам болон авто тээвэртэй хослуулан тээврийг зохион байгуулж байна. Бид онгоцны хувиарь, үнийн саналыг цаг тухайд нь танд мэдээлж тээвэрлэлтийн явцыг хянаж явдаг. Үүнд :

- Хятадын Сингань, Чиндао болон Жингтанг боомтоор дамжин өнгөрөх бүтэн чингэлгийн тээвэр (импорт, экспорт)
- Бүх төрлийн задгай тээвэр (импорт, экспорт)
- Бусад

Цуглуулбар ачааны тээвэр

Бүтэн чингэлэг эсвэл машин дүүрэхгүй ч цуглуулбар ачааны тээврийг сонгосноор ачааныхаа хэмжээнд таарсан бага хөлс төлөх оновчтой шийдлийг бид цуглуулбар ачааны тээврийн үйлчилгээгээрээ олгож байна:

- БНХАУ-ын бүх мужуудаас Эрээнд цуглуулбар хийгдэн Монгол улс руу
- Гуравдагч орноос БНСУ-ын Инчонд цуглуулбар хийгдэн долоо хоног бүр Монгол улс руу
- Гуравдагч орноос Хонг Конгд цуглуулбар хийгдэн долоо хоног бүр
- Европын холбооны орнуудаас Берлинд цуглуулбар хийгдэн гарах ачаа

Төслийн ачаа тээвэр

Уул уурхайн болон хэт овор ихтэй, аюултай ачаа болон том, бага төсөлийн ачаанд төлөвөллөгөө маршрут гарган тээвэр зохион байгуулна

Экспортын тээвэр

Бид Монгол улсаас таны хүссэн улс руу төмөр зам, агаар, авто зам, далайн гарцаар экспортын тээврийг зохион байгуулна.

Гаалийн бүрдүүлэлт

- ШАНДАСГОВЬ ХХК таны ачааг хаалганаас хаалганд хүргэх үйлчилгээг дэлхийн хаанаас ч тээврийн ямар ч төрлөөр (төмөр зам, авто зам, агаараар, далайгаар) хийж гүйцэтгэнэ. Бид бүтэн контейнэр(FCL), түүвэр ачаа(LCL), задгай ачаа, түргэн муудах болон аюултай ачаа зэрэг бүх төрлийн ачаан дээр шуурхай найдвартай тээвэрлэлтийг хийдэг. Үйлчлүүлэгч нар гадаад худалдааны гэрээ хийж эхлэх, ачаа барааг илгээх болон хүлээн авах орны хил гаалийн шаардлага болон бүрдүүлэх бичиг баримтын талаар мэдлэг, мэдээлэлгүйн улмаас цаг хугацаа алдах, илүү зардал гарах гэх мэт эрсдлүүдтэй байнга тулгарч байдаг. Иймээс олон жилийн туршлагатай манай хамт олноос мэргэшсэн зөвлөгөө аваарай.
- Бид Монгол улсын хил дээрхи болон гүний гааль дээр гаалийн бүрдүүлэлт, мэдүүлгийн үйлчилгээ үзүүлнэ.
- Экспорт Импортын гаалийн бүрдүүлэлт
- Ре-экспорт болон транзит гаалийн бүрдүүлэлт
- Татвар төлөлт, буцаан олголт
- АТА Карнэйтэй ачааг хүлээн авах, илгээх
- Гаалийн түр горимын бүрдүүлэлт
- Гааль татварын зөвлөгөө өгөх

Биднийг сонгох шалтгаан

Логистикийн оновчтой систем танай компанийн амжилтын түлхүүр гэдэгтэй та санал нийлэх үү? Бараа, бүтээгдэхүүнээ төлөвлөсөн цаг хугацаанд нь бүрэн бүтэн, эрсдэлгүй тээвэрлэн хүргэж, хэрэглэгчийнхээ захиалгыг тасралтгүй ханган нийлүүлэх чадамжтай байхын тулд танд логистикийн үр дүнтэй менежмент хэрэгтэй. Тэрхүү менежментийн багийг танай компани бүрдүүлэхийн тулд олон жилийн туршлага хэрэгтэйгээс гадна зардал өндөртэй. Харин мэргэжлийн тээвэр зуучлагч эсвэл тээвэр логистикийн компанитай гэрээ хийн аутсорсинг хийхээр шийдсэн бол танай компанийн бараа бүтээгдэхүүнээс авахуулаад бизнесийн төлөвлөгөө, компанийн зорилт хүртэл маш олон хүчин зүйлээс шалтгаалсан том шийдвэр гаргах шаардлагатай тулгарсан бол та яг одоо ШАНДАСГОВЬ ХХК-ийг сонгоход буруудахгүй гэж зөвлөж байна. Уг шийдвэрийг гарагсанаар:

- Танд бизнесийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй, хялбар болгоно
- Бага зардал гаргахын зэрэгцээ зардлаа хянахад хялбар
- Нийлүүлэлтийн гинжин хэлхээний оновчтой шийдлийг гаргана
- Компанийнхаа бусад чухал асуудлуудад төвлөрөх цаг гарна
- Хэрэглэгч тань сэтгэл ханамжтай үлдэх болно
- Тээвэрлэлттэй холбоотой алдаа гарах эрсдэл багасах ...гэх мэтчилэн олон талын ач холбогдолтой байх болно.

Манай ШАНДАСГОВЬ ХХК-ийн зүгээс өрсөлцөхүйц үнэ санал болгох бөгөөд үнийн урд найдвартай гэдэг үг хэзээд явдаг болохыг дуулгахад таатай байна.